

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МАХН ба Гоминьдан :

А. Амар нарын МАХН-ын төлөөчид Бээжин, Чуулалт Хаалганд зорчсон нь

Академигч Ж. Болдбаатар
Түүхийн ШУ-ны доктор Ц. Батбаяр

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд 1925 оны III-V сард МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгч А.Амар тэргүүтэй төлөөлөгчид Бээжин, Чуулалт хаалганд зорчиж, МАХН ба Гоминьдан намын хооронд дөрвөн зүйлтэй хэлэлцээрийг хэлэлцэн тохирсон төдийгүй, Хятадын цэргийн эрхтэн Фэн Юйсянтай удаа дараалан яриа хэлэлцээ хийж, монголчууд бие даан яриа хэлэлцээ хийж, эрх ашгаа хамгаалах чадвартайгаа харуулсныг архивын сан хөмрөгт тулгуулан өгүүлжээ.

Түлхүүр үг: МАХН, Гоминьдан, хятадын коммунист нам, үндэсний нэгдсэн фронт, Коминтерн, яриа, хэлэлцээр, автономит эрх

Монголын талаар 1925-28 онд Коминтернээс явуулсан бодлого нь Хятад дахь хувьсгалын ялалт, ялангуяа Гоминьдан ба ХКН-ын хооронд нэгдсэн фронт байгуулах бодлогод нийцэн захирагдаж байсан билээ. ОК(б)Н ба ЗОУ-ын Засгийн газар 1923 оны 3 дугаар сард Сунь Ятсэн, түүний Гоминьдан намд санхүүгийн болон зэр зэвсгийн тусламж үзүүлэх улс төрийн шийдвэр гаргажээ. ЗОУ 1923 оны 10 дугаар сард Гоминьдан намын дэргэд суух улс төрийн ахлах зөвлөхөөр М.М. Бородиныг томилон явуулсан байна.

ХКН 1923 оны 6 дугаар сард болсон III их хурлаараа Үндэсний нэгдсэн фронт байгуулах зарчмын шийд.г гаргаж, ХКН-ын зохион байгуулалтын бие даасан байдлыг авч үлдэхийг хамт ХКН-ын гишүүдийг Гоминьданд нэгдэн орохыг зөвшөөрөхөөр болжээ. Гоминьдан нам ч 1924 оны 1 дүгээр сард хийсэн анхдугаар их хурлаараа Үндэсний нэгдсэн фронт байгуулах бодлогыг тунхаглаж, ЗСБНХУ-тай холбоо тогтоох, ХКН-тай хамтран ажиллах, тариачин, ажилчдын хөдөлгөөнийг дэмжих гэсэн "Гурван их бодлого"-ын зарчмыг батлав. Коминтерн ч 1923-27 оны хооронд Хятад дахь үндэсний нэгдсэн фронтыг бүх талаар дэмжих, Хятадын хувьсгалыг ялуулах бодлогыг хатуу баримталж байв.¹

МАХН Коминтерны энэ бодлогыг түргэн шуурхай тусган авч намын II, III Их хурлын тогтоолууддаа тодорхой тусгасан байна. МАН 1924 оны 8 дугаар сард болсон III их хурлынхаа тогтоолд: "Бүх дэлхийн олон улсын эв хамтын намууд ба ялангуяа Алс Дорнод дахь Хятад, Японы эзэрхэг улсын ардын нам ба эв хамт намтай хэлхээ холбоо байгуулан харилцан явалцаж байвал хойчид тустай болов уу гэсэн тухайг хэлэлцээд эл намуудтай ийнхүү харилцан явалцаж, холбогдлыг зузаатгахыг эрхлэх нь зүйтэй" гэжээ. МАХН 1925 оны 3 дугаар сард хийсэн Бүгд хурлаар намын мөрийн хөтөлбөрийг батлан гаргасан бөгөөд 21 -р зүйлд Хятад үндэсний ашиг тусыг үнэхээр хамгаалах Сүн Ваны /Сунь Ятсэнийг хэлж байна/ байгуулсан Го Мин Дан гэдэг нам ба Хятад улсын Эв Хамтын нам энэхөөр бол аж үйлдвэрийн ба тариачин ардын ашиг тусыг дэлгэрүүлэхийг үнэхээр хичээж гуй" гэдгийг тэмдэглээд 40-р зүйлд :Учир иймийн тул манай ардын намаас Хятад улсын Го Мин Дан гэдэг нам ба Алс Дорнод зүгийн эв хамтын нам буюу бусад зэргэлдээ бүхий хувьсгалт ангиудтай харилцан туслалцах хэлхээ холбоо байгуулахыг хүсвэл зохино" гэж тунхаглажээ.²

Сүн Ваны байгуулсан Гоминьдан хэмээх ардын намтай холбоо тогтоох эхлэлийг НТХ-ны дарга япон хэмээх Б. Данзанг 1923 оны эцсээр Хятадад илгээж Гуаньчжоуд Сунь Ятсэнтэй, Бээжинд Гоминьданы удирдах хүмүүс, Фэн Юйсян нартай тус тус уулзуулж анхны хэлхээ холбоог тогтоосон билээ. МАХН-ын III их хуралд оруулсан ТХ-ны илтгэлд "Бидний монголчууд Умард Хятадын эзэрхэг харгисуудын түрэмгий бодлогыг зогсоохын

тулд Өмнөд хятадын Кантоны ардын засгийн газартай харилцаа тогтоовол зохино. Манай намын ТХ-ноос энэ зорилгын үүднээс япон Данзанг томилон Кантонд явуулсан бөгөөд бид Гоминьдан намтай эв санаа нэгтэй ажиллах алхам хийсэн билээ" гэжээ.

Бээжинд суугаа ЗХУ-ын Элчин сайд Л. Карахан 1925 оны 2-р сарын 15-нд Г.В. Чичеринд захидал илгээж "Монголоос цэргээ гаргаж авна хэмээн зарлах хэрэгтэй, тэгээд Монголын асуудал одоо бидэнд хамаагүй болсон, одоо Хятадын засгийн газарт монголчуудтай өөрсдийн аль хүссэнээр хэлэлцэн тохирох бүрэн бололцоо олгож байна хэмээн хятадын олон нийтэд мэдэгдэх хэрэгтэй" гэж бичиж байв. Тэрээр мөн "Монголчууд Бүгд найрамдах Хятад улсын бүрэн эрхийг зарчмын хувьд хүлээж, тус улсын бүрэлдэхүүн хэсэг байхыг зөвшөөрнө, үүнийг сайн дураараа хийхэд бэлэн байна. Харин хэд хэдэн болзол бий гэж мэдэгдэх ёстой. Энэ бол Хятадын бүрэн эрхийг аман дээрээ зөвшөөрөөд үүний сацуу хэрэг дээрээ Монголын асуудлыг шийдвэрлэх явдлыг олон он жилээр хойшлуулж байгаа юм.... Энэ бол монголчуудын баримтлах урьдчилсан үзэл бодол бөгөөд гэвч хэрвээ нөхцөл байдлын эрхээр шаардагдвал монголчуудыг автономит эрхтэй захирагдуулах, тэгэхдээ Москвад элчин сайдаа суулгах эрхтэй, өөрийн армитай байх эрхтэй өргөн автономи байхыг зөвшөөрүүлэхээр бодож бид хэдийн шийдвэрлэсэн юм" гэж бичиж байв.⁴

Гоминьдан намын тэргүүн Сунь Ятсэн /Сунь Вэнь ч гэдэг/ 1925 оны 3 дугаар сард нас барсан явдал МАХН ба Гоминьданы хооронд хэлхээ холбоог зузаатгах даацтай алхам хийх боломж олгов. МАХН-ын Төв Хороо Гоминьдан намын төвийн Гүйцэтгэх Хороонд эмгэнэл илэрхийлж цахилгаан утас явуулснаас гадна Сунь Ятсэний оршуулах ёслолд оролцох төлөөлөгчдийг томилох болов. Хятад улсад илгээх төлөөлөгчдийн талаар оон хувилбар дэвшүүлсэн боловч, эцэст нь МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн А. Амар тэргүүтэй намын төлөөлөгчдийг бүрдүүлжээ. Амар Ерөнхий сайдын орлогчийг хийж байсан боловч зөвхөн нам хоорондын харилцаа холбоог хэлэлцэх мандаттай байв. МАХН-ын Тэргүүлэгчдийн 1925 оны 3 дугаар сарын 16 болон 23-ны өдрийн хурлын тогтоолоос үзвэл Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ТХ-ны тэргүүлэгч А. Амар, ТХ-ны тэргүүлэгч Ж. Гэлэгсэнгэ, Дотоод яамны тэргүүн сайд Ц. Навааннэрэн, Улсын бага хурлын гишүүн урианхайн Тэвэгт нар оролцсоноос гадна Коминтерны төлөөлөгч Т. Рыскулов монголын казахуудын төлөөлөгч Хасагбай хэмээх нууц нэртэйгээр оролцон явсан байна. Уг төлөөлөгчид Сунь Ятсэнийг сүүлчийн замд нь үдэх ёслолд оролцохын зэрэгцээ Хятадын хувьсгалт нэгдсэн фронтод багтдаг байгууллагуудын эрх баригчид болон Фэн Юйсянтай уулзаж ажил хэргийн холбоог бататгах зорилготой байв. Түүнчлэн МАХН-ын төв архивт хадгалагдан буй Амар нарын удирдамжаас үзвэл Бээжин дэх Монгол-Төвдийн Хороотой холбоо барих, Банчэн Богдтой уулзах зэрэг даалгаврууд байжээ.⁵

Коминтерны төлөөлөгч Турар Рыскулов, Линдетэй хамтран 1925 оны 5 дугаар сарын 13-нд Коминтерны Дорнод хэлтэст бичсэн 59 хуудас дэлгэрэнгүй илтгэх хуудсаас МАХН-ын төлөөлөгчдийн Хятадад хийсэн айлчлалын дүр зургийг нэлээд бүрэн дүүрэн тодруулах боломж олдож байна. Хятадад МАХН-ын төлөөлөгчдийг илгээх асуудлыг Бээжинд суугаа Зөвлөлтийн Элчин сайд Л.М. Карахан анх Москвад тавьж, Гадаад хэргийн ардын комиссар Г.В. Чичерин зохих шийдийг гаргаж Улаанбаатарт үүрэг өгсөн бололтой. Хойд Хятадын цэргийн эрхтэн Фэн Юйсян 1924 оны 10 дугаар сард Бээжинг эзлэн авсны дараа Гоминьдан намын удирдагч Сунь Ятсэнийг Бээжинд ирэхийг урьснаас гадна ЗХУ-д хандан зэр зэвсэг болон цэргийн сургагч нарыг ирүүлж туслахыг 1925 оны эхээр хүсэлт тавьжээ.⁵

Фэн Юйсян Зөвлөлт Оросоос цэргийн тусламжийг зөвхөн БНМАУ-ын нутгаар дамжуулан авахаас өөр аргагүй байв. Иймд тэрээр Гоминьдан намтай хамтран ажиллаж буйгаа шалтаг болгон МАХН-ын төлөөлөгчдийг урьж Хятадад ирүүлэх хүсэлтийг Л.М.Караханд тавьжээ. Карахан Г.В.Чичеринд 1925 оны 3 дугаар сарын 1-нд бичсэн захидалдаа

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Монголын төлөөлөгчдийг Чуулалт Хаалганд Фэн Юйсянтай хэлэлцээ хийлгэхээр явуулахыг хоёр шалтгаанаар чухал гэж үзэн үндэслэжээ. Нэгд, Фэн Юйсян Хаалганд эзэн сууж Чахар, Суйюань хоёр муж, түүнчлэн Бээжин-Хаалганы төмөр замыг хянаж байгаа учраас монголчууд түүнтэй очиж Монгол-хятадын худалдаа болон бусад асуудлаар ямар нэг тохиролцоонд хүрэх хэрэгтэй. Хоёрт, монголчууд Хаалганд очихгүй байгааг тэрээр биднийг үүнд ямар нэг байдлаар саад учруулаад байна гэж буруу ойлгож магадгүй. Фэн бидэнд хандан 3 хүсэлт тавьсан. Зэр зэвсэгээр хангах, Москвад төлөөлөгчдийг нь хүлээж авах, Хаалган болон Хүрээний хооронд автомашины тээврийг зохицуулж өгөх гэсэн хүсэлтүүд тавьсан гэж Карахан Москвад бичжээ.⁶

Төлөөлөгчид 1925 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатараас 4 машинтай гарч 18 өдөр явж байж 4 дүгээр сарын 13-ны өдөр Чуулалт Хаалганд орой болсон хойно туйлдаж ядарсан улсууд хүрч очжээ. Хавар байсан учир цас их орж, хүчтэй цасан шуурга шуурч байснаас Чойр хүрэх боломжгүй болж Манжуурын замаар хойш эргэж Цэцэн ханы өргөөгөөр дамжин машин, тэмээ хослон явж байжээ. Цэцэн ханы өргөөгөөс Чойр хүртэл тэмээгээр явж, тэнд Хоршоодын төв холбооны ачаа бараа тээсэн 3 машин байсныг дайчилж Хаалган хүргүүлсэн байна.⁷

МАХН-ын төлөөлөгчид 4 дүгээр сарын 13-нд Хаалганд ирчихээд Фэн Юйсянтай уулзахаас өмнө Бээжинд очиж Л. М. Карахантай уулзах нь зүйтэй гэж үзжээ. Иймд Сунь Ятсэний булшинд хүндэтгэл үзүүлэх, Банчен Богдод бараалхах шалтагаар шалтаглан Хаалганд буудаллалгүй шууд Бээжин мордсон байна. Бээжинд очоод Монголын төлөөлөгчид Л.М. Карахантай уулзаж, Хятадын байдал, Фэнтэй хийх хэлэлцээний сэдэв, бие биедээ харилцан ямар шаардлага тавих талаар зөвлөгөө авсан байна. Рыскуловын бичсэнээр “Фэнтэй хийх хэлэлцээний бүх бэлтгэл ажлыг нөхөр Карахан, Бородин хоёр хийсэн гэдэг нь монголчуудад тов тодорхой болсон. Иймээс тэд зөвлөлтийн албан ёсны төлөөлөгчидтэй улам зоригтой харилцдаг болсон” гэжээ.⁸

Монголын төлөөлөгчдийг Бээжинд ирснийг мэдсэн Фэн Юйсян өөрийн зөвлөх Бау Шиже хэмээгчийг Хаалганаас Бээжинд илгээж амар мэндийг мэдэж, тэднийг Хаалганд буцаан ирүүлж яриа хэлэлцээ хийхийг урьжээ. Амар нар Бээжинд байхдаа тэнд өмнө нь ирээд байсан жонон ван Ширнэндамдинтай уулзаж Банчен богдын талаар асууж лавлаж, түүнд хэрхэн бараалхах талаар зөвлөлдсөн байна. Түүнчлэн ДМАХН-ын Фу Минтай, Байюнти /Цэрэндондов/ нар Бээжинд манай төлөөлөгчидтэй уулзаж Фэн Юйсянтай яриа хэлэлцээ хийхэд туслах хүсэлтээ илэрхийлжээ. Хаалган буцахын өмнө Амар нар Сунь Ятсэний булшинд очиж МАХН-ын нэрийн өмнөөс хүндэтгэлийн цэцэг өргөжээ.

МАХН-ын төлөөлөгчид Бээжинд 3 хоносны дараа галт тэргээр хөдөлж Хаалганд өглөө үүрээр 4 цагт ирсэн байна. Тэднийг Фэн Юйсяны армийн штабын дарга Чжан Жунжун, гадаад харилцааны хэлтсийн дарга Тан Юлян нар угтан авчээ. Фэн төлөөлөгчдийг угтан авч олон хоног замд саатаж, цасан шуургыг туулж ирсэнд баяр хүргээд хамт өглөөний цай уусан байна. Тэр өдөртөө Амар нар Фэн Юйсяны байранд очиж авч ирсэн бэлэг /хадаг, цаг, булганы арьс/ зэргийг гардуулж, Фэн-тэй цуг Сунь Ятсэний хэлсэн үгийг эгшигт хайрцагаар сонсож, Гоминьдан намын удирдагчийн дурсгалыг хүндэтгэжээ.

Ажил төрлийн анхны хуралдаан хоёр талын төлөөлөгчдийн бүрэн бүрэлдэхүүнтэй эхэлжээ. Фэн Юйсяны талаас штабын дарга Чжан Жунжун, зөвлөх Бау Шиже, Хаалган ба Чахар мужийн захирагч /дутун/ Чжан Жизян, Гадаад хэргийн хэлтсийн дарга Тан Юлян, Гоминьдан намын төлөөлөгчид Кунг Сянжи, Сю Чэн нар оролцов. Монголын талаас төлөөлөгчид мөн орчуулагчид оролцжээ. Монголын талаас төлөөлөгчдийн тэргүүн Амар эхлэн үг хэлэв. МАХН Фэн Юйсяны урилгыг Москвагаар дамжуулан Караханаас хүлээн авсан. Фэн ямар асуудлаар урьсныг мэдээгүй. Гэвч Фэнтэй хэлэлцээ хийнэ, Хятадын улс төрийн бусад бүлэгтэй хэлэлцээ хийхгүй. МАХН Фэныг үнэхээр ард түмний зүтгэлтэн гэж үздэг, иймээс хэлэлцээ хийхээр төлөөлөгчдөө ирүүлсэн гэж хэлэв.⁹

Фэн Юйсян хэлсэн үгэндээ Бээжинд эргэлт хийж, хуучин эзэн хааныг хөөсөн /Манжийн сүүлчийн хаан Пу И-г ордноос нь хөөснийг хэлж байна Ц.Б./ Тэгээд нөхөр Караханаар дамжуулан Монгол улстай холбоо барихыг хүссэн. Өнөөдөр түүний мөрөөдөл биелэж Монголын төлөөлөгчидтэй хэлэлцээний ширээний ард сууж байгаадаа их баяртай байна. Фэн цааш нь Юань Шикайн үеийг оролцуулан Хятадын товч түүхийг ярьжээ. Фэн үгийнхээ төгсгөлд 1. Монголчууд ба Фэны зам нийлэх ёстой. 2. Нягт зузаан найрамдлын холбоо тогтоох хэрэгтэй. 3. Хувьсгалын зорилтыг хамтдаа биелүүлбэл зохино. 4. Хэлэлцээнд хоёр тал илэн далангүй нээлттэй байх нь зүйтэй гэжээ.¹⁰ Түүнчлэн Фэн Зөвлөлтийн цэрэг Монголлоос үнэхээр гарсан эсэх, монголчууд түүний армид цэргээр туслаж чадах эсэх гэсэн хоёр асуудлыг онцлон хөндөж байв. Эцэстээ Фэн монголчуудад тавих саналаа бичгээр өгөх, монголчууд мөн хариу саналуудаа бичгээр өгөхөөр тохирчээ.

А.Амар Фэны бичгээр тавьсан саналуудыг МАХН-ын Төв Хороонд 1925 оны 4 дүгээр сарын 21-нд илгээсэн анхны цахилгаан утсандаа танилцуулжээ. Фэн Монголоос хоёр зүйлийг хүсэж байна. 1. Монголчууд Фэны армийн ар талаас цэргийн ажиллагаа нээхгүй байх, 2. Монголын нутгаар дамжуулан зэр зэвсэг зөөж авчрах бололцоог олгох. Монголын талаас Фэнд хандан мөн 3 шаардлага тавьжээ. 1. Өнөөдөр Монголд бүрэлдсэн байдлыг /статус квог/ тэр чигээр нь орхих, 2. Монгол бие даасан, тусгаар тогтносон улс гэдгийг хүлээн зөвшөөрөх, эсвэл энэ асуудлыг үндэстний өөртөө засан тохинох эрхийн үндсэн дээр шийднэ гэж үзэх 3. Монголын нутаг дэвсгэрт цэрэг оруулахгүй байх, шинэ Монголын дайснуудад хятадад орогнох байр олгохгүй байх. Нэмэлт асуудлууд болгон 1/ Улаанбаатар болон Чуулалт Хаалганы хооронд машин тэрэг явуулах онц эрхийг монголчууд, орсоуд болон Фэн Юйсянд олгох, бусад этгээдийн машиныг энэ замаар явуулахгүй байх, 2/ Монгол, Хятадын хоорондын хилийн асуудлыг хэлэлцэх, Баргад өргөн автономи эрх олгох зэрэг асуудлуудыг хэлэлцэхээр Фэн санал болгож байгаа тул МАХН-ын Төв Хорооноос дээр дурдсан бүх асуудлаар хэлэлцээ хийж болох эсэхийг асуулгасан байна.¹¹

Хаалганд байгаа монголын төлөөлөгчид хоорондоо зөвлөлдсөний үндсэн дээр төлөөлөгчдийн тэргүүн А. Амарыг Фэн Юйсянтай ганцаарчлан уулзуулж тодорхой асуудлуудаар илэн далангүй ярилцах нь оновчтой гэж үзжээ. Ингээд А. Амар Фэны байранд орчуулагчийн хамт очиж биеслэн уулзаж, тодорхой асуудлуудыг хоёр тал бие биендээ тавьсан байна. Юуны өмнө Амар ба Фэн нар Монголын тусгаар тогтнолын тухай асуудал Монголын ард түмний хүсэл зориг болон Хятадын чөлөөлөх тэмцлийн үйл явдлын үр дүнгээс хамаарах тул хожим хэлэлцэхээр орхиж, тодорхой асуудлуудаа ярилцая гэж тохирчээ. Фэнтэй биеслэн ярилцсан яриагаа А. Амар 4 дүгээр сарын 22-ны өдөр МАХН-ын Төв Хороонд цахилгаан утсаар дамжуулж ТХ-ны саналыг асуулгасан байна.

Амар цахилгаандаа Фэны тавьсан 5 асуудлыг дараах байдлаар танилцуулжээ.

1. Хоёр тал хоорондоо телеграфаас гадна радио холбоо барьж байх
2. Фэн Юйсян Жан Золинтай байлдах тохиолдолд Монголын тал цэргийн хүчээр Гирин мужийн нутгаар цэргийн тусламж үзүүлэх
3. Хаалган-Хүрээ-Хиагтын замыг ашиглахад Орос, Хятад хоёр монополь эрх тогтоох
4. Монголын нутаг дэвсгэрээр дамжуулан зэвсэг авахыг зөвшөөрөх
5. Монголын бүрэн эрхт төлөөлөгчийг Хаалганд ирүүлж суулгах

Амар цахилгаандаа өөрийн саналыг мөн бичжээ. Тэрээр Фэны тавьсан 5 саналаас 1, 4, 5 дугаар саналыг хүлээн авахад онц төвөггүй мэт гээд 3 дугаар саналыг нэгэнт Карахан хүлээн авчихсан тул Монголын эрх ашигт хохиролгүйгээр энэ асуудлыг хэлэлцэх, харин 2 дугаар асуудлыг хүлээн авах боломжгүй гэж хариулсан, цэргийн хүчээр туслаж чадахгүй, харин морь худалдах яриа байж болох юм гэжээ. Монголын талаас Фэнд мөн 4 шаардлага тавьсныг танилцуулжээ. Үүнд:

1. Монголын тухайн байдлыг /статус квог/ Фэн Юйсян хүлээн зөвшөөрөх
2. Монголын бие даасан байдлын тухайд гэвэл энэ асуудлыг үндэстний өөртөө засан тохинох нийтлэг үндэслэл дээр шийдвэрлэх

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

3. Монголын нутагт цэрэг оруулахгүй байх

4. Баргад өргөн автономит эрх олгох¹² гэжээ.

Улаанбаатараас хариу иртэл дор хаяж 7 хоног болох тул Рыскулов, орос хэлний орчуулагч Галан, Өвөр Монголын Фу Минтай нар 4 дүгээр сарын 22-ны тэр өдөртөө Бээжин орж Караханд яриа хэлэлцээний явцын тухай танилцуулахаар явсан байна. Хоёр өдрийн дараа Хаалганд үлдсэн Монголын төлөөлөгчид бүгд мөн Бээжинд хүрэлцэн иржээ. МАХН-ын төлөөлөгчид Бээжинд ийнхүү 2 дахь удаа ирэхдээ Бээжин дэх Гоминьдан намын Улс төрийн Зөвлөлийн гишүүдтэй уулзаж, тус хоёр намын харилцааны асуудлыг хэлэлцсэн байна. Тэдэнтэй Гоминьдан намын Бээжин дэх Зөвлөлийн нөлөө бүхий гишүүн, ХКН-ын удирдагчийн нэг Ли Дачжао тэргүүлэн хэлэлцээ хийснээр МАХН ба Гоминьданы харилцааны тухай 4 зүйлийг 1925 оны 4 дүгээр сарын 26-нд хэлэлцэн тохирч чаджээ. Үүнд:

1. Хоёр улсын ардын нам Сунь Вэнь авгайн ард угсаа өөрөө таслах зорилгыг /үндэстний өөртөө засан тохинох эрхийг хэлж байна/ журамлан явна.
2. Хоёр улсын ардын намаас өөр өөрийн зорилго, суртлыг дэлгэрүүлнэ.
3. Хоёр улсын ардын намаас харилцан төлөөлөгч томилно.
4. Хоёр улсын ардын нам хэрэг тохиолдвоос харилцан туслалцана гэжээ.¹³

Энэхүү нам хоорондын 4 зүйлт хэлэлцээрийг тохиролцоход Коминтерний төлөөлөгч Т. Рыскулов Монголын казахуудын төлөөлөгч Хасагбай нэрээр оролцжээ. Т.Рыскулов Гэлэгсэнгийн хамт түрүүлэн Улаанбаатар буцаж 5 дугаар сарын 1-нд хүрэлцэн иржээ. 3. Лонжидын бичсэнээр Т. Рыскулов зөвлөлтийн иргэн, Коминтерний төлөөлөгч болохыг хятадууд гадарласантай уялдаж түүнийг Гэлэгсэнгийн хамт Монгол руу эгүүлэн татаад Н. Жадамба, С. Нацов хоёрыг нэмэн илгээсэн гэжээ.¹⁴

Оросын архивын материалаас үзвэл Элбэгдорж Ринчиног Бээжинд, С. Нацовыг Хаалганд явуулах асуудал бас яригдаж байжээ. 1925 оны 5-р сарын 6-нд Монголоос Коминтернд илгээсэн цахилгаанд : "Рыскуловын саналаар, Төв Хорооны тогтоол ёсоор Ринчино Бээжинд Гоминьдан намын дэргэд суух Ардын намын төлөөлөгчөөр очно. Рыскулов Фэн Юйсян дээр эргэж очихыг эрс татгалзаж, өөрийн оронд Нацовыг явуулж байна. Рыскуловын ийм үйлдэл нь Фэнийг монголчуудыг сэжиглэх явдлыг улам ихэсгэж болох юм. Ринчиногийн Бээжинд, Нацовын Чуулалт Хаалганд очихыг зөвшөөрөх эсэх тухай яаралтай мэдэгдэнэ үү." гэж бичиж байжээ.¹⁵

Төлөөлөгчид мөн Банчин богдтой уулзаж, түүнийг Монголд урих удирдамжтай байв. Дотоод яамны тэргүүн сайд Ц. Навааннэрэнгийн өөрийн нь бичсэнээр: "Барга, Дотоод монголчуудыг хувьсгалын зүгт хандуулахад татахад тустай болов уу хэмээн намын Төв Хорооноос чухалчлан үзэж явуулсан хэрэг бүлгээ" гэжээ. Навааннэрэн Банчин богдтой удаа дараа уулзаж, БНМАУ-ын Засгийн газраас түүнийг Монголд биеэр залрах урилгыг гардуулсан байна. Харин Банчин богд "Энэ удаа очиж чадахгүй, дараа очъё" хэмээн татгалзсан хариу өгчээ.¹⁶

Рыскуловын Коминтернд бичсэн илтгэх хуудаснаас Банчин богдын тухай зарим зүйлийг тодорхой болгох бололцоо гарч байна. МАХН-ын төлөөлөгчид Бээжинд хоёрдахь удаа ирэхдээ Банчин богдод бараалхжээ. Өмнө нь Бээжинд ирсэн байсан жонон ван Ширнэндамдин төлөөлөгчдийг Банчин богдтой уулзуулах бүх ажлыг зохион байгуулж, уулзах өдөр цагийг тогтоосон байна. Мөн түүгээр дамжуулан Засгийн газрын захидал, бэлэг сэлтийг урьдчилан өгүүлжээ. Рыскулов шүтлэгтэй монголчуудаас эрхбиш эмээж Банчен богдод тэднийг дагаж бараалхаагүй байна. Амар нар Банчин богдод монголчууд хятадуудад хэрхэн ханддаг тухай, монголын хүн ам Банчен богдыг шүтдэг, түүнийг Монголд ирэхийг хүсэн хүлээдэг тухай, Бээжинд ирж буй сүсэгтэн олныг хэрхэн чирэгдүүлж байгаа тухай, мөн хятадууд Банчен Богдыг Бээжинд байгааг ашиглан элдэв өдөөн хатгалга хийж магадгүй тухай нэлээд илэн далангүй ярилцсан байна.¹⁷ Банчин лам Монголд очих тухай эртнээс мөрөөдөж ирснээ тэдэнд яриад, Бээжинд хэрхэн ирсэн тухай,

хятадын төр засгийнхан түүнд хэрхэн хандаж байгаа тухай ярьж байжээ. Рыскуловын ажигласнаар Амар, цэцэн хан Навааннэрэн нар Банчин Богдыг хятадуудаас салгаж авах, түүнийг Монголд аваачихыг үнэн сэтгэлээс хүсэж байх шиг байсан гэжээ.¹⁸

Амар нарын төлөөлөгчдийн айлчлалын хамгийн төвөгтэй асуудал бол Фэн Юйсянтай хийсэн яриа хэлэлцээг дуусгах явдал байв. Фэн Юйсян 1924 оны 10 дугаар сард Чжили-Фэнтяний дайны үед У Пэйфу-гийн эсрэг бослого гаргаж, Бээжинг түр ч болов эзлэн авч Гоминьдан нам, цаашилбал ЗОУ-тай ойртох бодлого явуулснаар Коминтерний анхаарлыг татаж чадсан юм. Тэрээр Сунь Ятсэнийг дэмжиж буйгаа илэрхийлж, өөрийн армийг Гоминцзюнь буюу ардын арми хэмээн нэрлэх болсон байлаа. Тэрээр БНМАУ-тай шууд хиллэх Чахар, Суйюань онцгой бүсүүдийг захирч байснаас гадна Баруун хойд хил хязгаарыг төвшитгөх сайд /дубань/ -аар томилогдсон явдал нь Коминтерн, ЗОУ-ын Хятадын нэгдсэн фронтыг дэмжих бодлогод нийцэж байв. Москва түүний хүсэлтийн дагуу Фэн Юйсяний армид цэргийн туслалцаа үзүүлэх шийдийг 1925 оны 3 дугаар сард гаргаж В.К. Путна тэргүүтэй цэргийн сургагчдыг 1925 оны 4 дүгээр сард Хаалган хотод ирүүлжээ.¹⁹

А.Амар тэргүүтэй төлөөлөгчид анх Бээжинд ирээд ЗОУ-ын Элчин сайд Л.М. Карахантай уулзсаныг өмнө өгүүлсэн билээ. Карахан Фэн Юйсянтай харилцаа тогтоох, түүнийг Чжан Цзолины эсрэг хүч болгон ашиглах ЗОУ-ын бодлогыг танилцуулаад Хаалганд очиж Фэнтэй уулзаж яриа хэлэлцээ хийхийг зөвлөжээ. Үүнд Фэн Монголоор дамжуулан ЗОУ-аас зэр зэвсгийн тусламж авах, мөн Монголын зүгээс түүний ар тал руу дайралт хийхгүй байх хоёр хүсэлт тавьж байгаа. Монголын тал үүний хариуд Гадаад Монголын статус-квог хүлээн зөвшөөрөх, Монголын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулахгүй байх зэрэг шаардлагуудыг тавихыг зөвлөсөн байна. А. Амар нар Чуулалт хаалганд 4 дүгээр сарын 18-нд очсон бөгөөд 4 дүгээр сарын 21-нд Фэнтэй уулзав. Фэн Монголын төлөөлөгчдөд 5 зүйлтэй хэлэлцээр байгуулах санал тавьж хэлэлцээрийнхээ төслийг гардуулжээ. Амар үүнийг Улаанбаатарт МАХН-ын Төв Хороонд 4 дүгээр сарын 22-нд илгээсэн цахилгаандаа бичиж дамжуулсныг өмнө өгүүлсэн билээ.

А.Амар МАХН-ыг төлөөлж, төрийг төлөөлөхгүй удирдамжтай тул Фэний саналд хариу өгөх боломжгүй байв. Иймд МАХН-ын Төв Хороо, дарга Ц.Дамбадоржид хандан Фэний саналд ямар хариу өгөх тухай захидал илгээсэн байна. Төвөөс хариу ирэх хооронд А. Амар нар дахин Бээжин орж Гоминьдан намтай хэлэлцээ хийхийн хамт Банчин богдтой төлөөлөгчдийн нэг хэсэг нь уулзжээ. Гоминьдан намтай 4 зүйлийг хэлэлцэн тохирсны дараа Ж. Гэлэгсэнгэ, Турар Рыскулов нар буцаж очоод 1925 оны 5 дугаар сарын эхээр Төв Хорооны тэргүүлэгчдэд илтгэлээ тавьж хэлэлцүүлжээ.

Намын ТХ-ны тэргүүлэгчид Гэлэгсэнгэ, Рыскулов нарын илтгэлийг сонссод Гоминьдан намтай харилцах зарчим, Фэн Юйсянд туслах арга хэмжээний тухай тогтоол гаргасан байна. Түүнд: Фэн Юйсянтай Монголын засгийн газрын төлөөлөгч сайд болон Ерөнхий сайдын орлогчийн нэрийн өмнөөс хэлэлцээр байгуулах /ингэснээр БНМАУ-ыг дам хүлээн зөвшөөрүүлэх/, Монгол улсын дотоод хэрэгт үл оролцох, монголын хязгаарт цэрэг түлхэн оруулахгүй гэсэн үүргийг Фэн-ээр авахуулах, Монгол улсын дайсан этгээдтэй гэрээ холбоо байгуулахгүй, тэдэнд ямарваа туслалцаа үзүүлэхгүй байх, Хөлөнбуйрт өргөн автономит эрх олгуулах, Дотоод Монголын ардын эрхийг хүндэтгэн үзэж, үндэс угсаанд харштай хэргийг үл явуулах, мөнхүү газраа ардын намын явдлыг бүрэн бүтнээр гүйцэтгэж явуулах эрх олгох. Мөн Фэн Юйсян хятадын засгийн эрхийг авмагцаа Өвөр Монгол зэрэг өөр угсаатанд өөртөө засан тохинох эрх олгохыг зөвшөөрвөл хэлэлцээр байгуулж болно гэжээ. Фэн Юйсяний хүсэлтийн тухай заахдаа: Монгол улсаас Фэн Юйсяний аливаа хэрэгт тустай санаа тавьж байх, тус улсын нутаг дээгүүр зэр зэвсэг нэвтрүүлэх, хэрвээ чухал хэрэг тохиолдвол тус улсаас албан газраар уламжлан морь худалдан авч байх, харин Монгол улсаас Фэн Юйсянд туслах цэрэг гаргахгүй, мөн түүний

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

дайсан этгээдийг Монголын нутаг дээр хүч хуримтлуулахыг зөвшөөрөхгүй байвал зохино гэсэн байна.²⁰

Жадамба, Нацов нар 5 дугаар сарын 9-нд Хаалганд хүрэлцэн иржээ. А.Амар нар НТХ-ны Тэргүүлэгчдийн 5 дугаар сарын 3-ны өдрийн тогтоолыг хүлээн авсны дараа Фэнтэй 5 дугаар сарын 10-нд уулзаж тогтоолын заалтуудад үндэслэсэн нийт 5 зүйлтэй хэлэлцээрийн төслийг гардуулсан байна. Фэн түүнийг хүлээн авахаас татгалзсан байна. Харин тэрээр 5 дугаар сарын 19-нд 9 зүйлтэй шинэ төслийг Амарт гардуулжээ. Фэн шинэ төсөлдөө БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхийн талаар заалт оруулахаас эрс татгалзаж, харин Хөлөнбуйр, Дотоод Монголд өөртөө засах эрх олгох, засгийн эрхийг авсан тохиолдолд Дотоод Монголчуудад өөртөө засан тохинох эрх олгох амлалт авснаас гадна Фэний арми болон Улаанбаатарын хооронд харилцан төлөөлөгч томилон суулгах, Фэний армид зэр зэвсэг нэвтрүүлэх, морь тэмээ худалдан авах боломж олгох, автомашины тээх нэвтрүүлэх хороог байгуулах заалтуудыг чухалчлан оруулжээ.²¹

1925 оны 5 дугаар сарын эцсээр Хятадын байдалд огцом өөрчлөлт гарч Чжан Цзолин Тяньжинд хүрэлцэн ирж Бээжин өөд давших, Фэн Юйсянтай шинэ дайн хийх аюул үүссэн тул ЗОУ Фэнгийн армид туслах, түүнд зориулсан зэр зэвсгийг Улаанбаатараар дамжуулан олгох шийдвэрийг 5 дугаар сарын 28-нд гаргажээ. Ийнхүү байдал өөрчлөгдсөн тул Бээжинд суугаа ЗОУ-ын элчин Л.Караханы шаардлагаар А.Амар нарын төлөөлөгчид Фэнтэй хийж байсан хэлэлцээг дуусгалгүй орхиж, 5 дугаар сарын 29-нд Улаанбаатар өөд хөдөлсөн байна. ЗОУ-ын хүсэлтээр Фэний армийн штабын дарга Чжан Юнрун А.Амар нарын төлөөлөгчдийн хамт 40 гаруй автомашин, хөсөг авч Улаанбаатарт хүрэлцэн иржээ.

Чжан Юнрун БНМАУ-ын Засгийн газарт хандаж зэвсэг ачих автомашин, мөн тэрэг сэлбэх багаж хэрэгсэл ба Хар мөрөн мужийн түүгээр Чжан Цзолинтай байлдах нэгэн анги цэрэг туслах, харилцан төлөөлөгч суулгах зэрэг хүсэлт тавьжээ. МАХН-ын ТХ-ны тэргүүлэгчид уг хүсэлтийг 1925 оны 6 дугаар сарын 4-ний 31 дүгээр хурлаараа хэлэлцээд зэвсэг ачих автомашин, сэлбэг хэрэгслийг зохих хөлсөөр нь олж туслах, цэргээр туслахыг үл хэрэгсэх, харилцан төлөөлөгч суулгахыг зөвшөөрвөл зохино гэсэн шийдвэр гаргажээ.²²

Чжан Юнрун өөрийн туслах Чэнь Зияны дуг Улаанбаатарт төлөөлөгчийн газраа нээж суусан байна. МАХН түүнийг Фэний төлөөлөгч гэхээс илүү Гоминьдан намын төлөөлөгч гэж нэрлэн тэр байдлаар харьцаж байсан байна. Фэн Юйсяний армид ЗСБНХУ-аас зэвсэг тогтмол нийлүүлэх ажил 1925 оны 6 дугаар сараас эхэлжээ. 1925 оны 9 дүгээр сард Чуулалт хаалга хотноо гурван этгээдийн хэлэлцээ хийж, автомашины тээх нэвтрүүлэх хоршоо байгуулах хэлэлцээрт гарын үсэг зурж уг хэлэлцээрийн дагуу 1925 оны 11 дүгээр сард Улаанбаатар-Чуулалт Хаалга, Улаанбаатар-Дээд Үдийн хооронд автомашины байнгын тээвэр нээсэн байна. Зөвлөлтийн тал тээврийн зардалд зориулан хорин мянган америк доллар гаргасан байна.²³

1925 оны 5 дугаар сард МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 26-р хуралдаанаар Гоминьдан намтай холбоо барих МАХН-ын Төв Хорооны төлөөлөгчөөр Ц.Гүрсэдийг томилон Бээжин хотноо 1925 оны 6 дугаар сарын эхээр явуулжээ. Түүний бичсэн илтгэх хуудаснаас үзвэл: "...заасан газарт хүрч Гоминьдан намын бөгөөд Эв хамт намын гишүүн Ли Дачжао нартай юуны өмнө учран хоёр намын хооронд хэлхээ батыг үүсгэн хөгжүүлэх" арга замыг сүвэгчилж оролдсон байна. Гүрсэдийн хийж гүйцэтгэсэн ажлын чухал хэсэг нь урьд нь А.Амар нарын хэлэлцэн тохирсон МАХН ба Гоминьдан намын хооронд тогтоох 4 зүйлт хэлэлцээрийн үндсэн эхийг зөвшилцөн боловсруулсанд оршино.

Гүрсэд Бээжинд 2 сар гаруй байх хугацаанд ЗОУ-ын элчин Л.Карахантай байнгын холбоотой байснаас гадна Гоминьдан намын Бээжин дэх Улс төрийн зөвлөлийн гишүүд, ялангуяа Ли Дачжао нартай хэд хэдэн удаа уулзаж А. Амар нарын тохиролцсон 4 зүйлийг үндэс болгон хоёр намын хооронд хамтран ажиллах хэлэлцээрийн эхийг тохиролцох зорилгоо илэрхийлжээ. Гоминьдан нам Сунь Ятсэн өөрийн биеэр боловсруулж өмнө нь Б.Данзан нараар хүргүүлсэн 7 зүйлт төслийг баримтлах санал тавьсан боловч Гүрсэд үүнийг хүлээж авах боломжгүй гэдгээ илэрхийлжээ. Ийнхүү хоёр тал А.Амар нарын 4

зүйлийг баримтлахаар үндсэндээ тохирч хэрвээ бүх ажил бүтэлтэй байвал 1925 оны 8 дугаар сард Гуаньчжоуд болох Гоминьдан намын их хурлаар оруулж батлуулахаар болсон байна.

Гүрсэд, Ли Дачжао нарын хэлэлцэн тохирсон дэлгэрэнгүй агуулгатай 4 зүйлт хэлэлцээрийн эх бичгийн 1-р зүйлд Хятадын Гоминьдан нам Хятадын бүх угсаатны өөртөө засан тохинох эрхийг /право на самопоределение/ хүлээн зөвшөөрнө гэдгийг дурдаад "...монгол угсаатныг болбаас түүний эрх чөлөө олох явдлыг бүрнээ эрхэмлэн хүндэтгэнэ. Гагцхүү Дундад улсын ардын намаас /Гоминьданыг хэлж байна/ туйлаар хүсэх болбаас Дундад улсын ард угсаатан монголын ард угсаатантай туйлын янаг ах дүүгийн найрамдал ба холбоог байгуулахыг хүснэ. Иймийн тул Дундад улсын хувьсгалын явцад бүтсэний хойно хоёр ард угсаатны ашиг тус тэгш болсны үес хоёр ард угсаатан өөр өөрийн дур санаагаар эрх тэгш холбоотой болохыг эрмэлзэнэ" гэжээ. Өөрөөр хэлбэл хятадын хувьсгал ялсны дараа монгол, хятад хоёр тэгш эрхтэйгээр нэгдэн нийлж нэгэн федерац буюу холбооны улс байх ирээдүйн төлөвийг тусгасан байна.

Хэлэлцээрийн төслийн бусад зүйлүүдэд хоёр нам тус тусын зорилгыг сурталчлах, харилцан төлөөлөгч суулгах, харилцан туслалцах үүргийг өмнөхөөс илүү тодруулж өгчээ. Тухайлбал, 4-р зүйлд : Дундад улсын аль нэгэн этгээд ба бус дайсан этгээдээс Монголд халдаар орох буюу халдах аваас Дундад улсын ардын намаас зүй нь ард түмэндээ ухуулж, дарлагдагч лугаа нэгэн адил хэмээн мэдүүлнэ. Хэрэв Дундад улсын Ардын намын этгээдэд ийнхүү явдал тохиолдвоос Монгол ардын нам мөн нэгэн адилаар үүргийг хүлээнэ"²⁴ гэжээ. Гүрсэд хэлэлцээрийн талаар Гоминьданы төвөөс ирэх хариуг хүлээн Бээжинд сар гаруй суусан боловч хариу ирсэнгүй тул 8 дугаар сарын сүүлийн хагаст Монгол буцжээ.

Хятадад сууж байсан Элчин сайд Л.М.Карахан 1925 оны 5 дугаар сарын 7-нд Г.В.Чичеринд илгээсэн захидалдаа Амар нарын айлчлал хятадуудын хувьд ч тэр, монголчуудын хувьд ч тэр их ач холбогдолтой болсныг бичиж байв. Тэрээр Монголчуудын хувьд тэд анх удаа олон улсын тавцан дээр гарч, өөрсдийгөө нэр хүндтэй өндөр түвшинд авч явсан нь гоминьданчууд болон Фэн Юйсянд нааштай сэтгэгдэл төрүүллээ. Монголчууд хятадын коммунистууд болон зүүн үзэлтэй гоминьданчуудаас бусад ихэнх хятадууд Монголыг Хятадын нэг хэсэг гэж үздэгийг сайтар ойлгож авлаа. Ингэснээр тэд Монголын бие даан орших цорын ганц баталгаа нь ЗХУ-тай нягт хамтын ажиллагаа тогтоох гэдгийг ойлгож авлаа гэж бодож байна гэж бичиж байв.²⁵

Коминтерны төлөөлөгч Турар Рыскулов Амар нарын МАХН-ын төлөөлөгчид Бээжин, Чуулалт Хаалганд очсон явдлын ач холбогдлыг дараах байдлаар бичиж Коминтернд танилцуулж байжээ. "Монголын төлөөлөгчид хүрэлцэн очиж хэлэлцээ хийсэн нь цагаа маш сайн олсон.Эдгээр хэлэлцээний үр дүнд...гурван тал бүгдээр хожиж байна. Юуны өмнө нөхөр Чичерин болон Караханы урилгаар Фынтэй хэлэлцээ хийхээр Монголын ийм нэр хүндтэй төлөөлөгчид хүрэлцэн очсон нь Монгол Улс Зөвлөлт Оросын үгийг нэлээд итгэлтэй сонсож байгааг болон эргээд Зөвлөлт Орос улс Монголын саналыг харгалздагийг харуулж байна. Монголын байдлын тухай бодит мэдээлэл өгч, Монголоос зөвлөлтийн цэрэг гарсныг албан ёсоор баталсан, Зөвлөлт Орос улс бүхий л буурай орнуудад түүний дотор Монголд үзэл санаагаар болон үнэхээр найрсагаар ханддагийг баталсан хийгээд нөхөр Карахан монголын төлөөлөгчдийг Фынтай уулзуулах амлалтаа ёсчлон гүйцэтгэсэн ... эд бүгд Зөвлөлт Оросын империализм, Монгол дахь улаантны цэргийн дарангуйллын тухай, монголчууд хавчигдаж байдаг тухай Фын болон түүний тойрон хүрээлэгчдийн санааг харсаар байтал сарниулж, Карахан болон Хятадад суугаа Зөвлөлтийн бусад төлөөлөгчдийн нэр хүндийг Фыныг харсаар байтал улам өргөж өгсөн юм. Фыны тухайд гэвэл тэр Монголын төлөөлөгчидтэй уулзан ярилцсанаараа ажил үйлдэлдээ бодит тусламж авах боломжтой болсон төдийгүй тийм бүрэн эрхтэй төлөөлөгчидтэй хэлэлцээ хийснээрээ өөрийн цэргийн болон орчин тойрны хүн амын өмнө ёс суртахууны хувьд өргөгдсөн юм. Фынтай холбоо тогтоосноор Монголыг хятадууд

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

зарим талаар хүлээн зөвшөөрснийг илэрхийлж байгаагаар энэ хэлэлцээ монголчуудад ч ашигтай болсон юм”²⁶ гэж Рыскулов дүгнэн бичжээ.

Рыскулов мөн илтгэлийнхээ төгсгөлд Амарын тухай дараах хэдэн зүйлийг үнэлэн бичжээ. “Эцэст нь Амарын тухай хэдэн үг хэлмээр байна. Тэр бол эргэлзээгүй ухаалаг, чадвартай монгол хүн болохоо харууллаа. Үнэндээ, тэр бол ясны үндэсний үзэлтэн (твердый националист) мөн бөгөөд монголын эрх ашгийг хэнд ч худалдахгүй, үүний сацуу Монгол улс ч тийм төрөлхийн авьяаслаг хүмүүсгүй бол (без таких самородков) байж чадахгүй. Тэр нэлээд хүлээцтэй дипломат, өөрт нь өгсөн удирдамжийг эцэст нь хүртэл баримталдаг чин үнэнч хүн болохоо эдгээр хэлэлцээний үед харуулсан” гэж үнэлэн бичиж байв.²⁷

Ийнхүү МАХН-ын төлөөлөгчдийн айлчлал үнэндээ ЗОУ-ын бие төлөөлөгчид Л.М.Карахан, М.М.Беродин нарын удирдамж заавраар хэрэгжсэн боловч А.Амар нарын ухаалаг чадварлаг улс төрчдийн үйл ажиллагааны үр дүнд МАХН ба Гоминьдан намын хооронд анхны дөрвөн зүйлт хэлэлцээрийг хэлэлцэн тохирсон төдийгүй, Хятадын цэргийн эрхтэн Фэн Юйсянтай удаа дараалан яриа хэлэлцээ хийж, монголчууд бие даан яриа хэлэлцээ хийх, бодлоо чиг шугамаа хамгаалах чадвартайг илтгэн харуулж, улс орныхоо тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх, Өвөр монголчуудад өргөн автономит эрх олгуулах асуудал дээр хатуу зогсож, Улаанбаатар-Хаалганы хооронд автомашины тээвэр хийлгэх асуудлаар ч үндэснийхээ эрх ашгийг бодолцсон тохиролцоо хийж байжээ. Энэхүү айлчлал XX зууны хөр орны харилцааны түүхэн дэх бие биеэ ойлголцох гэсэн хамгийн анхны том алхам байв.

Abstract

MPRP and Gomindan: visit of A. Amar and other delegation of MPRP to Beijing and Chuulalt Khaalga
The article considers visit of A. Amar, member of the Presidium of the Central Committee of MPRP, and other delegation to China and their meeting with delegation of Gomindan Party and general Fin Yusyan.

¹ Jian Bozan, Shao Xunzeng and Hu Hua. A Concise History of China, Beijing, Foreign Languages Press, 1981. Pp. 152-156.

² МАХН их бага хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр. 1-р хэсэг. 1921-1939. УБ., 1956. 59-р тал. 104-р тал.

⁴ Монголын тухай БХК ЁН-ын баримт бичигт. Баримтын эмхтгэл. 1-р боть. 1920-1932. УБ., 2002. 180-182-р тал.

⁵ Үндэсний Түүхийн Архив, ф. 4, Д. 1, ХН. 363, х. 55.

⁶ Новейшая история Китая /1917-1927/, М., 1983, с. 188-192.

⁶ Переписка И.В. Сталина и Г.В. Чичерина с Полпредом СССР в Китае Л. М. Караханом /1923-1926 гг./ М., 2008, с. 460-461.

⁷ РГАСПИ, ф. 495, оп. 152, д. 33, л. 7-9.

⁸ Там же, л. 9-10.

⁹ Там же, л. 16.

¹⁰ Там же, л. 16-17.

¹¹ Там же, л. 43.

¹² Там же, л. 44.

¹³ НТТА. Фонд 1. Товьёг. 34. ХН. 20. Ж. Болдбаатар, Амар сайд, УБ., 1993, 28-р талаас иш татав.

¹⁴ З. Лонжид. Наваандожийн Жадамбын улс төрийн намтар. УБ., 1997. 25-р тал.

¹⁵ Монголын тухай БХК ЁН-ын баримт бичигт. Баримтын эмхтгэл. 1-р боть. 1920-1932. УБ., 2002. 183-р тал.

¹⁶ Л. Бат-Очир. Халхынхаадын төгсгөл. УБ., 2001. 69-р тал.

¹⁷ РГАСПИ, ф. 495, оп. 52, д. 33, л. 34.

¹⁸ Там же, л. 34-35.

¹⁹ C. P. Atwood. Young Mongols and Vigilants in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931. Volume one. Brill, Leider, 2002. P. 323.

²⁰ Л. Жамсран. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. УБ., 1997, 180-181-р тал.

²¹ C.P. Atwood. Young Mongols and Vigilants in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931, Leiden, Brill, 2002, vol. 1, pp. 343-346.

²² Л. Жамсран, Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. 181-р тал.

²³ С.Г. Лузянин. Россия- Монголия- Китай в первой половине XX века. С. 153.

²⁴ НТТА. Фонд 1. Товъёог. 34. ХН 20. Л. Жамсран. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт, 182-183-р талаас иш татав.

²⁵ Переписка И.В. Сталина и Г.В. Чичерина с Полпредом СССР в Китае Л. М. Караханом, М., 2008, с. 500-503.

²⁶ РГАСПИ, ф. 495, оп. 152, д. 33, л. 28-29.

²⁷ Там же, л. 36.